

## Амбагай Хотулыг хаан болгохоор захисан уу ?

Ж.Гэрэлбадрах

Монголын түүх судлалд төдийлөн сайтар судлагдаагүй түүхэн үе бол Хабул ханаас Есүхэй баатар хүртэлх үеийн Монголын түүх ажээ. Түүх судлаачид Чингис хааны үеийн Монголын түүхийг товойлгон авч, тал бүрээс нь тодорхой судалсан атлаа түүний өмнөх үеийг ихэнхидээ үйл явцыг тоочих, эсэхүл сурвалжийн мэдээг нягтлалгүйгээр шууд авч хэрэглэх байдлаар өгүүлсээр иржээ.

XII зууны Монголын түүхийн зарим нэг зүйлийг урьд өмнө бичиж тодорхойлж байснаас өөрөөр нотлон тайлбарлаж болохуйц байна. Энд Амбагай Хотулыг хаан болгохоор захисан эсэхийг тухайлан авч үзье. Монголын хоёрдахь хаан Амбагай Татарт баригдаад Бэсүд овгийн Балхачийг элч болгон илгээж, ийн хэлүүлжээ. "*Qabul qahan-nu dolo'an k'öd-ün dumdadu Qutula-da ügülerün harban k'öd-ün dотор Qada'an-taisi-da ügüle ke'en ügülejü ilerün qamuq-un qahan ulus-un ejen bolju öki-ben ö'esün hüdeküi-ben nama'ar kesetkün Tatar irgen-e bariqda'a bi tabun quru'ud-iyān kimul tamutala harban quru'ud-iyān ha'uttala hač mini aburan sori [t] ke'ejü ilejü'ü*"<sup>1</sup> (Хабул хааны долоон хөвүүний дундад Хутулад өгүүллүүн арван хөвүүдийн дотор Хадаан тайшид өгүүл хэмээн өгүүлж илгээн хамгийн хаан, улсын эзэн болж охиноо өөрөө үдэхээ надаар хэсэтгүн Татар иргэнээ баригдав би. таван хуруудаа химүл тамтал арван хуруудаа хагуттал ачи минь аварун сори хэмээж илгээж). Энэ захиасанд Амбагай хаанаас Татар аймагт баригдах буруу хэрэг хийснээ Хотула, Хадаан хоёрт тоочоод өшөөгөө авахыг захисан байна.

Мөн үүнийг Хабул хааны хөвүүн Хияд овгийн Хотула, өөрийн хөвүүн Хадаан хоёрын аль нэгийг Монголын хаан болгохоор гэрээслсэн захиас болохыг "Нууц товчоон"-д өгүүлэх дараагийн мэдээнээс төвөггүй мэдэж болно. Үүнд "*Ambaqai qahan-nu Qada'an Qutula qoyar-i nereyitčü ilekse'er qamuq Mongqo [l] Tayyič'ut Onan-nu Qorqonaq-jubur quraju Qutula-yi qahan bolqaba*"<sup>2</sup> (Амбагай хааны Хадаан, Хутула хоёрыг нэрийдэж илгээснээр Хамаг Монгол, Тайчиуд нар Ононы Хорхонуг жубур хураж Хутулыг хаан болгов) хэмээн өгүүлдэг.

Д.Гонгор, Амбагай хааны гэрээслэн захисан ёсоор Хотула хан суусан хэмээн үзсэн байна<sup>3</sup>. Н.Ишжамцын үзснээр бол "Амбагай урвагч татар ноёдод баригдаж, Алтан улсад хүргэгдээд цаазаар авахуулахын өмнө Хабулын хүү Хоталаар хаан ширээ залгамжлуулах гэрээслэл хийснийг Хамаг Монголын сурвалжтан нар биелүүлсэн байна. Сурвалжтаны хуралдаан ханы захиас гэрээслэлийг дагаж, түүнийг ёс төдий хэлэлцэн батлахаас хэтрэхгүй

<sup>1</sup> Histoire secrete des Mongols. par Louis Ligeti. Budapest., 1971. p. 34.

<sup>2</sup> Histoire secrete des Mongols. par Louis Ligeti. Budapest., 1971. p. 36.

<sup>3</sup> Гонгор Д. Халх товчоон. I.УБ., 1970. т. 73.

болж байжээ”<sup>4</sup>.

Харин Ч.Далай Амбагайг “...хааны орыг Хабулын дунд хүү Хотулад залгамжлуулж, миний дунд хүү Хадаан тайш хоёр дахь хүн нь болж яваарай хэмээн захисан удаатай байжээ. Энэ нь Балхачи элчээр хэлүүлсэн гэрээс дотор Хотулын нэрийг нэгд, Хадаан тайшийн нэрийг хоёрт дурдснаар тодорхой болсон байна”<sup>5</sup> хэмээн арай дэлгэрүүлж авч үзжээ.

Гэтэл Амбагай хааны захиасанд эхлээд Хотула, удаад нь Хадааны нэр гарах хэдий ч түүнд Хотулыг хаан, Хадааныг түүний дараах хүн нь болоорой гэсэн шууд утга санаа төдийлөн харагдахгүй байна. Тэгээд ч түүний дараахан хаан сонгох үйл явцыг өгүүлэхэд Хадааны нэр эхэнд нь, Хотулын нэр дараа нь гарч байна.

Монголын хааныг сонгохоор бүх монголчууд, тайчууд нар Хорхунаг жубурын хөндийд цугларан хэлэлцсэн тэр үйл явдлыг “Нууц товчоон”-д “*Ambaqai qahan-nu Qada'an Qutula qoyar-i nereyitcū ilekse'er qamuq Mongqo [!] Tayyicū't Onan-nu Qorqonaq-jubur quraju Qutula-yi qahan bolqaba*”<sup>6</sup> (Амбагай хааны Хадаан, Хутула хоёрыг нэрийдэж илгээснээр Хамаг Монгол, Тайчиуд нар Ононы Хорхонуг жубур хураж Хутулыг хаан болгов) хэмээжээ.

“Нууц товчоон”-д гарч буй дээрх хоёр хэсэг мэдээнээс үзэхэд Амбагай хаан Хотула, Хадаан хоёрын хэн нэгийг илүүтэй авч үзээгүй, зөвхөн тэр хоёрыг хуралдаанаар хэлэлцэж, аль нэгийг нь хаанаар сонгохыг захисан гэлтэй байна. Амбагай хааны захиасанд Хотула, Хадаан хоёрын нэр ээлжлэн байраа сольж гарч байгаа нь үүний нэгэн нотолгоо болж болох юм. Хэрэв Амбагай үнэхээр Хотулыг хаан болгохоор хэлсэн бол Хадааны нэрийг эхлэн дурдахгүй л байлтай. Тэгээд ч хэн нэгийг нэрийг урьд, хойно бичснээр түүхэн баримтыг тайлбарлах нь ихэд өнгөц шинжилгээ болдог.

Амбагай хааны Балхач буюу Бүлгачаар дуу бариулан (*dayu bariyulqu yosun*) ирүүлсэн дээрх захиасын утгыг нарийвчлан үзвэл, эхэн хэсэг нь Хотулад зориулж хэлсэн, үндсэн хэсэг нь Хотулаар дамжуулан өөрийн хөвүүн Хадаанд буруу хэрэг хийснээ тоочин сургамжаа хэлж, өш хонзонгоо авахыг даалгасан байдалтай байна. Үүнийг баримталбал Хотула хаан болох магадлалтай нэгдүгээр хүн болж харагдана. Гэтэл Хадаанд захисан сургамжиндаа “*qamuγ-un qahan ulus-un ejen bolju öki-ben ö'esün hüdeküi-ben nama'ar kesetkün*”<sup>7</sup> (хамгийн хаан улсын эзэн болж охиноо өөрөө үдэхээ надаар хэсэтгүн) хэмээн өгүүлдэг. Энэ нь Хадааныг хаан болбол баримтлах цээрлэх зүйлийн нэг болж байна. Энэ бүхэн Хотула, Хадаан хоёрын хэн нэгийг онцлон заагаагүйг гэрчилж буй гэлтэй.

Рашид-ад-диний үзснээр, Амбагай хааныг нас барсны дараа түүний хөвүүд, төрөл төрөгсөд, Тайчууд аймгийн ноёд цугларч, түүний оронд хэнийг хаан суулгах талаар удтал зөвлөлдөж байжээ<sup>8</sup>. Хэрэв Амбагай хаан Хотулыг хаан болго хэмээн нэр заан гэрээсэлсэн бол тийнхүү цугларч удтал зөвлөлдөх хэрэг байсан уу? Тэгээд ч Тайчиуд нар уг хурлаас тодорхой шийдвэр гаргаж чадаагүй байна. Эл мэдээ Амбагай хаан Хотулыг хаан болго хэмээн захиагүй болохыг харуулж байгаа нэг баримт болох юм.

Хадаан Тайчууд аймгаа тэргүүлсэн хэвээр байсан ба эцгийн орыг залгаж Монголын хаан болж болох байтал түүний ах дүү нар үгсэн хуйвалдаж, түүний хаан болох боломжийг алдагдуулжээ<sup>9</sup>. Тодруулж хэлбэл, Тайчууд нар дотроо эв түнжин муутай, хагарал тэмцэлтэй

<sup>4</sup> Ишжамц Н. Монголд нэгдсэн төр байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь. УБ., 1974. т. 35.

<sup>5</sup> Далай Ч. Монголын түүх. Хамаг Монгол улс (1101-1206). УБ., 1996. т. 50.

<sup>6</sup> Histoire secrete des Mongols. par Louis Ligeti. Budapest., 1971. p. 36.

<sup>7</sup> Histoire secrete des Mongols. par Louis Ligeti. Budapest., 1971. p. 34.

<sup>8</sup> Рашид-ад-дин. Сборник летописей. т. I. кн. II. М.-Л., 1952. стр. 44-45.

<sup>9</sup> Рашид-ад-дин. Сборник летописей. т. I. кн. II. М.-Л., 1952. стр. 26.

байсны улмаас хаан ширээг Нирун-Хияд аймагт алдсан байна. Чухам тэдний энэ эв нэгдэлгүй байдал Монголын дийлэнхи овог аймгуудын ноёд язгууртнуудыг Нирун-Хияд овгийн Хотулыг дэмжихэд хүргэжээ.

Тэдний уг эв түнжингүй байдал дараа дараагийн үед ч үргэлжилсэн юм. Тайчиуд аймгийг толгойлж байсан Хадаан тайж нас барсны дараа намар нь Тайчиуд нар цугларч толгойлогчоо сонгохоор хэлэлцсэн боловч Түдүр билгэ, Таргудай хирүлтүг нар мөн л тохиролцоонд хүрч чадаагүй байна<sup>10</sup>. Судлаач Ч.Хишигтогтох уг зөвлөлгөөн дээр үг хэлсэн Матухан сэцнийг "Лу.Алтан товч"-ид нэр гардаг Хүдэй сэцэнтэй адилтгасан<sup>11</sup> нь нотолгоо муутай болжээ. Учир нь Хотулыг хаан болсны хойно Хадаан тайж нас барсан билээ.

Хотула хааныг нас барсны дараа ч, Есүхэй баатрыг хорлогдсон хойно ч тэд нэгдмэл байж чадаагүй тул Монголыг тэргүүлэн захирч чадаагүй хэвээр байв. Өөрөөр хэлбэл, Амбагайгаас хойш Тайчиуд аймгаас Монголын хаан гарч чадаагүй ажээ.

Язгууртны хуралдай тийм ч амар хялбар явагдаагүй бөгөөд Нирун-Хияд, Тайчууд аймгийн ширүүн маргаан тэмцлээр дүүрэн болж өнгөрчээ. Хуралдаанд Нирун-Хияд аймгийнхан Хабул хаан хөвгүүн Хотулыг хаан болгохоор оролцсон бол Амбагай хааны хөвгүүд, тэр дотроос тухайн үедээ Тайчууд аймагт голлох хүн гэгдэх Хадаан тайж ах дүү нарын дэмжлэгтэйгээр Монголын хаан болохоор тэмцсэн байна. Гэхдээ Тайчууд нар бүгдээрээ Хадааныг дэмжих нэгдсэн нэг саналтай байж чадаагүй байна.

Уг ноёдын хуралдай дээр Хүдэй сэцэн "*ta amaqai qaγan-u arban köbegüd aburi jang tan-u maγui aqū albatu qaračus bolqu ta tede qabul qaγan-u doluγan köbegüd ey-e ebtei-yin küčün-tür qatū-un qaγan ulus-un ejen bolumui j-a*"<sup>12</sup> (Та Амахай хааны арван хөвүүд авир зан тань муу албат харцас болох та, тэд Хабул хааны долоон хөвүүд эе эвтэйн хүчинд хамгийн хаан улсын эзэн болмуу за) хэмээн өгүүлсэн нь уг язгууртны хуралдаан ширүүн өрсөлдөөн, тэмцэл дүүрэн болсон ба Монголын язгууртнуудын дийлэнхи Хотулын хаан болохыг дэмжиж байсныг харуулж байна.

Хүдэй сэцний тийнхүү сургамжлан хэлсэн нь судлаач Цойжийн өгүүлдэгчлэн Амбагай хааны Хотулыг хаанд өргөмжлөх, Хадааныг улсын тайшид хэвээр байлгах гэрээслэлийг түүний хөвүүд эс биелүүлж хаан болох гэсэн оролдлого гаргасантай нь холбоотой<sup>13</sup> бус ажээ. Тухайн үеийн Монголд "улсын тайш" "*ulus-un taiysi*" гэсэн албан тушаалтан байгаагүй<sup>14</sup> бөгөөд энэ бол хаан ширээний төлөөх жирийн нэгэн тэмцэл байв.

Судлаач Р.Сайшаал Амбагай хааны орыг Хотула, Хадаан хоёрын нэгнээр залгамжлуулах гэрээсэлж үлдээсэн хэмээн үзсэн<sup>15</sup> нь зөв зүйтэй юм. Язгууртны хуралдаан Амбагай хааны нэр заасан Хадаан, Хотула хоёрыг хэлэлцээд олонхийн саналаар Хотулыг Монголын хаанаар өргөмжилсөн байна.

Тийнхүү Монголын анхны хаан Хабулын хөвүүн Хотула ноёд язгууртны хуралдаанаас хаанд өргөмжлөгджээ. Иймд Амбагай ганц Хотулыг хаан болгохоор шууд нэр заан гэрээсэлсэн, түүнийг нь язгууртны хуралдаан ёс төдий хэлэлцэн баталсан гэх нь өрөөсгөл дүгнэлт болон хуучрах болж байна.

<sup>10</sup> Рашид-ад-дин. Сборник летописей. т. I. кн II. М.-Л., 1952. стр. 45.

<sup>11</sup> Хишигтогтох Ч. Эртний Монгол шүлгийн түүвэр. Хөх хот., 1985. т. 108-109.

<sup>12</sup> Лувсанданзан. Эртний хадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршвой. УБ., 1990. т. 12а.

<sup>13</sup> Алтан товч. Цойж тулган харгуулж тайлбарлав. Хөх хот., 1999. т. 72-73.

<sup>14</sup> Гэрэлбадрах Ж. XII зууны Монголд "тайш" гэдэг албан тушаалтан байв уу. Acta Historica t.V. УБ., 2004.

<sup>15</sup> Сайшаал Р. Чингис хааны товчоон. Хөх хот., 1987. т. 48.

## SUMMARY

*J.Gerelbadrakh*

### **Did Ambaqai qahan order that Qutula be king ?**

It is widely accepted in the field of Mongolian historical studies that the second qahan (king) of the Mongols, Ambaqai qahan, was captured by the Tatars and compelled to make his plans for succession known.

Historians have argued that in accordance with Ambaqai qahan's last testament, Qutula assumed the kingship of the Mongols.

The present work suggests that this historical argument is in need revision. According to historical sources such as the "Secret history of the Mongols", the "Compendium of chronicles", and the "Altan tobci" of Lubsandanzan, Ambaqai qahan stated in his testament that either Qutula or Qada'an will become qahan of Mongolia through the selection process of the meeting of nobles.